



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/130.

Номгон

Аймгийн аюулгүйн нөөцөд өвс татан авах,
худалдан борлуулах үнэ тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн “а” дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарны 08-ны өдрийн 14 тоот хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :


1.“Ачит нуурын арвин хишиг хоршоо”-оос хандиваар өгсөн 1000 боодол, худалдан авсан 1471 боодол, Траст трейд, Эрдэнэ Хүнс ХХК-аас хандиваар өгсөн 1000 боодол өвс, нийт 3471 боодол өвсийг Сум дундын ойн ангийн орлогод авсугай.

2.Хандиваар ирсэн, худалдан авсан өвсний зарж борлуулах үнийг хавсралтаар баталсугай.

3. “Ачит нуурын арвин хишиг хоршоо”-ноос худалдаж авсан 1471 боодол өвсний үнэ 5,884,000 (таван сая найман зуун наян дөрвөн мянга)-н төгрөг, тээвэрлэж ирсэн 2471 боодол өвсний үнэ, тээврийн зардалд 12,355,000 (арван хоёр сая гурван зуун тавин таван мянга)-н төгрөг, нийт 18,239,000 (арван найман сая хоёр зуун гучин есөн мянга)-н төгрөгийг өвс худалдан борлуулсаны орлогоос төлж барагдуулахыг Сум дундын Ойн анги орон нутгийн өмчит үйлдвэрийн газар (П.Уртнасан)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигтбаатар)-т даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

1210513

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны
өдрийн 3/130 дугаар захирамжийн хавсралт



ХАНДИВААР ИРСЭН БОЛОН ХУДАЛДАН АВСАН ӨВСНИЙ ЗАРЖ
БОРЛУУЛАХ ҮНИЙН ТООЦОО

Д/д	Аж ахуй нэгжийн нэр	Утга	Гарал үүсэл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/	Тээврийн зардал /төг/	Нийт дүн /төг/	Худалдан борлуулах үнэ /төг/	Дансанд төвлөрүүлэх дүн /төг/
1	Ачит нуурын арвин хишиг хоршоо	Хандив	Увс аймаг Бөх мөрөн сум	1,000	-	5,000	5,000	9,500	9,500,000
2	Ачит нуурын арвин хишиг хоршоо	Худалдан авсан	Увс аймаг Бөх мөрөн сум	1,471	4,000	5,000	9,000	9,500	13,974,500
3	Траст трейд, Эрдэнэ Хүнс ХХК	Хандив	Дорнод аймаг	1,000	-	-	-	13,000	13,000,000
	Дүн			3,471	-	-	-	-	36,474,500